

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

МАК ЦЕМЕНТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТТУЛГА

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ МАК
ЦЕМЕНТ ХХК-ИЙН ХӨХ ЦАВЫН ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН ТӨСЛИЙН
2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5830974

ТАНИЛЦСАН:

УУРХАЙН ДАРГА

A stylized signature in black ink.

Т.ЦЭРЭНДАШ ✓

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Э.Батсайхан*

Э.БАТСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

A stylized signature in black ink.

Г.УУГАНБАТ -Г

2026 ОН

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
ХӨХ ЦАВЫН ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	5
УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	1
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН	1
БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	2
1.1 Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:	2
1.2 Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:	3
1.3 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	4
1.4 Ургамлан бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	5
1.5 Ногоон байгууламжийн төлөвлөгөө	6
БҮЛЭГ 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	6
БҮЛЭГ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	6
БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ	7
БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА	7
БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	8
БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	11
БҮЛЭГ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ	16
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Уурхайн байршлын зураг	6
---------------------------------------	---

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Солбицол.....	5
Хүснэгт 2. Уулын ажлын горим	7
Хүснэгт 3. Автосамосвалын бүтээл.....	8
Хүснэгт 4. Хөрс тээвэрлэх хугацаа	8
Хүснэгт 5. Автосамосвалын бүтээл.....	8
Хүснэгт 6.Шохойн чулуу тээвэрлэх хугацаа.....	9
Хүснэгт 7. Агаарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	2
Хүснэгт 8. Усан орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ ..	3
Хүснэгт 9. Хөрсөнд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	4
Хүснэгт 10. Амьтан, ургамалд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	5
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөө	6
Хүснэгт 12. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	7
Хүснэгт 13. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	8
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний мониторинг	11
Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө	13
Хүснэгт 17.Олон нийтэд тайлагнах хуваарь	14
Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний урьдчилсан зардал	16

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга: “Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг юм. Манай компани уул уурхай, барилгын материалын үйлдвэр, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цавын цемент шохойн үйлдвэрийн төсөл болон дагалдах уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 оны 04-р сарын 16-нд “МАК Цемент” ХХК байгуулагдсан.

Компанийн байгаль орчны бодлого:

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах нь компанийн нийт ажиллагсадын нэн тэргүүний зорилт болно.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, дүрэм, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл болох учиртай.

Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;

- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

ХӨХ ЦАВЫН ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

“МАК Цемент” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Билүүт багийн нутагт байрлах 9427А тусгай зөвшөөрөлтэй 273 га талбайтай Хөх цавын шохойн чулууны уурхайн үйл ажиллагааг явуулж цемент шохойн үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилготой. МАК Цемент ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Хөх Цавын шохойн чулууны ордын нөөцөд тулгуурлан европ стандартын портланд цемент болон металлургийн шохой үйлдвэрлэдэг МАК Евро цемент үйлдвэрийг ашиглалтад оруулсан бөгөөд Монгол улсын барилга, дэд бүтэц, зам, үйлдвэрлэлийн салбарын цемент, шохойн гол нийлүүлэгч болоод байна.


Төслийн үндсэн зорилго нь Хөх Цавын шохойн чулууны ордын нөөцийг эдийн засгийн үр өгөөж өндөртэй, байгаль орчинд сөрөг нөлөө бага хувилбараар оновчтой олборлох, үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, мөн компанийн бизнесийн зорилтыг хэрэгжүүлэх оновчтой шийдлийг тодорхойлох явдал юм.

Хөх цавын шохойн чулууны уурхай нь баттай (А) нөөцийг 28.24 сая.тн-оор, боломжтой (С) нөөцийг 76.294 сая.тн. ТЭЗҮ болон зураг төслийг “Грийт Вишн” ХХК, БОННУ-г “Баялаг эко” ХХК хийж гүйцэтгэсэн.

МАК цемент ХХК-ийн MV-009427 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, 272.69 га талбай бүхий Хөх цавын шохойн чулууны орд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Бичигт нэртэй 2-р багийн нутаг дэвсгэрт орших бөгөөд Улаанбаатар хотоос 305 км, УБТЗ-ын 25-р зөрлөгөөс баруун урагш 14 км зайд, МАК цемент ХХК-ийн цементийн үйлдвэрээс 12 км тус тус зайд байрлана. Мөн тус орд нь МАК ХХК-ийн хайгуул болон олборлолт явуулж байгаа Хөөтийн нүүрс-шатах занарын ордоос 100 км, Алагтогоо-Элдэвийн чулуун нүүрсний ордоос 34 км зайтай байрладаг байна.

Хүснэгт 1. Солбицол

Талбайн хэмжээ, га	Булангийн цэгүүдийн дугаар	Уртраг			Өргөрөг		
		град	мин	сек	град	мин	сек
272.69	1	45	56	41.62	108	49	41.7
	2	45	55	56.62	108	49	41.7
	3	45	55	56.62	108	48	41.7
	4	45	56	6.62	108	48	41.7
	5	45	56	6.62	108	48	1.69
	6	45	56	41.62	108	48	1.69



Зураг 1. Уурхайн байршил

Физик газарзүй: Физик газарзүйн мужлалаар төслийн талбай нь Төв Азийн заримдаг цөл, цөлийн их мужид хамаарна. Төв Азийн заримдаг цөл, цөлийн их муж нь 657,614.5 км² бөгөөд нийт МУ-ын нутаг дэвсгэрийн 42 хувийг эзэлдэг. Алтайн ар болоод өвөр говь, Говь-алтайн нуруу, говийн дорнод хэсэгт багтах бөгөөд гадарга нь урт удаан хугацааны туршид элэгдэл, эвдрэлд гүн өртсөн, цөлийн гандааст автан харлаж, өгөршлийн улмаас элдэв дүрс хэлбэртэй болсон, гадаргын ус ховор, гандуу хуурай уур амьсгалын нөхцөлд үүсэж тогтворжсон цөлжүү хээр, заримдаг цөл, хээржүү цөл, өмнөдийн цөл, хэт гандуу цөлийн ландшафт тархдаг.

Цөлөрхөг хээрийн байгалийн бүс бүслүүр. Монгол орны цөлөрхөг хээрийн бүс нь уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр байгаль орчны эмзэг байдал улам нэмэгдэж буй бүс нутгийн нэг юм. Энэ бүсийн онцлог нь хур тунадас бага, ууршилт ихтэй, хөрсний үржил шим багатайгаас гадна салхи, элсний нүүдэл ихтэй байдаг. Сүүлийн жилүүдэд цөлжилт эрчимжиж, бэлчээрийн талхагдал, усны хомсдол, ургамал, амьтны төрөл зүйлийн өөрчлөлт зэрэг олон асуудал хурцаар тавигдаж байна.

Төслийн талбай нь цөлөрхөг хээрийн бүсэд орших ба уур амьсгал сүүлийн жилүүдэд эрчимтэй өөрчлөгдөж байна. Жилийн дундаж температур 2.2-2.5°C-ээр нэмэгдэж, хур тунадасны хэмжээ 15-20%-иар буурсан нь энэ бүсийн байгалийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Гангийн давтамж нэмэгдэж, жилийн 5-8 сард хуурайшилт хүчтэй ажиглагдах болсон нь бэлчээрийн ургамалжилтад сөргөөр нөлөөлж, амьтан, ургамлын амьдрах орчныг доройтуулж

байна. Иймээс усны менежментийг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Уурхайн ажлын горим, ажиллах хүч:

Боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадлаас хамааран уурхайн олборлолтын ажлыг жилийн 4 улирал явуулна. Ил уурхай нь хоногт хоёр ээлжээр ажиллах бөгөөд нэг ээлжийн үргэлжлэх хугацаа нь 12 цаг байх ба хоолны болон ээлж солилцох хугацаа ээлж тус бүрт 1 цагаар тооцов. Хөдөлмөрийн хуулийн дагуу жилд амрах баяр, ёслолыг 9 хоногоор, цаг агаарын хүндрэл 34 хоног, засвар үйлчилгээ 63 хоног байхаар тооцоход жилд ажиллах хоногийн тоо 260 байна. Уулын ажлын горимыг хүснэгт 5-д үзүүлэв.

Уулын ажлын горим

Хүснэгт 2. Уулын ажлын горим

Д.д	Үзүүлэлт	Хугацаа
1	Ээлжийн тоо	2
2	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12
3	Ээлжин дэх амралт	1
4	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	1
5	Бүтээлтэй ажиллах цаг	10
6	Ээлжийн цаг ашиглалт	0.71
7	Календарийн хоног	365
8	Жилд сул зогсох өдөр	106
9	Үндэсний баяр, ёслол	9
10	Цаг агаарын хүндрэл	34
11	Засвар үйлчилгээ	63
12	Нийт сул зогсолт	106
13	Жилд ажиллах хоног	259

Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажил: 2026 онд 876.5 мян.м³ хөрс хуулах бөгөөд хөрсийг уурхайн баруун хойно байрлах хөрсний II овоолгод байршуулна. 2026 онд хөрс тээврийн зай дунджаар 2.0 км байхаар төлөвлөгөөнд тусгав. Хөрс хуулалтын ажилд батлагдсан техникийн хуваарийн дагуу 4.6 м³ утгуурын багтаамжтай CAT-374F экскаватор, 60 тн даацтай CAT-773E 3ш тус тус ажиллана.

Хүснэгт 3. Автосамосвалын бүтээл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	CAT-773E
1	Тээвэрлэх зай	км	2.0
2	Тээвэрлэх хурд / дундаж/	км/цаг	27.3
3	Тээвэрлэх хугацаа	мин	18.8
4	Ачих хугацаа	мин	2.53
5	Нийт цикл	мин	18.41
6	Автосамосвалын цагийн эргэлт	машин/цаг	15.89
7	Экс.цагийн бүтээл	м3/цаг	195.5
8	Тэвшний багтаамж	м3	27.6
9	Экс.-н цагийн машин эргэлт	машин/цаг	7.37
10	Циклийн машины тоо	ширхэг	2.56
11	Автосамосвалын бэлэн байдал	%	0.81
12	Автосамосвалын цаг ашиглалт	%	0.78
13	Циклийн машины тоо (бүхэл)	ширхэг	3
14	Экс.н бэлэн байдал	%	0.86
15	Экс.н цаг ашиглалт	%	0.82
16	Автосамосвалын цагийн бүтээл	м3/цаг	76.4

Хүснэгт 4. Хөрс тээвэрлэх хугацаа

Хово-371, САТ-773		Замын төрөл	Зай, м	Тээвэрлэх хурд		Туулах хугацаа		Нийт туулах хугацаа, мин
Уурхай Мөргөцөг	Овоолго			ачаатай, км/цаг	ачаагүй, км/цаг	Ачаатай, мин	Ачаагүй, мин	
R1-1	2	Налуу	450	20	25	0.75	0.60	3.35
		Дотор	1,100	30	30	2.04	1.70	2.74
		Гадна	450	35	35	1.50	1.29	5.79
		Нийт	2,000		27.5			18.8

Шохойн чулуу олборлолт, тээвэрлэлтийн ажил: 2026 онд 1.45 сая.тн шохойн чулуу олборлох бөгөөд олборлолтын ажил уурхайн баруун хэсэгт +1245 -1240 м, 1240 -1235 м +1235-1230 м, 1230-1225 м, 1225-1220 м, нийт 5н түвшинд **А, В-III, В-IV, В-V, В-XI, В-XII, В-XIII, В-XVIII** блокуудад явагдана. Шохойн чулуу олборлолт, тээвэрлэлтийн ажилд батлагдсан техникийн хуваарийн дагуу **4.6 м³** утгуурын багтаамжтай CAT-374F экскаватор **1 ш**, эхний хагас жилд 54 тн даацтай Хово-371 автосамосвал **8 ш**, сүүлийн хагас жилд 90 тн даацтай XGE-136E автосамосвал **5 ш** тус тус ажиллана.

Хүснэгт 5. Автосамосвалын бүтээл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	HOWO-371
1	Тээвэрлэх зай	км	13
2	Тээвэрлэх хурд/ дундаж/	км/цаг	30.3
3	Тээвэрлэх хугацаа	мин	45.9
4	Ачих хугацаа	мин	4.69
5	Нийт цикл	мин	59.6
6	Автосамосвалын цагийн эргэлт	машин/цаг	1
7	Экс.цагийн бүтээл	м3/цаг	217.29
8	Тэвшний багтаамж	м3	21.6
9	Экс.-н цагийн машин эргэлт	машин/цаг	8.7
10	Циклийн машины тоо	ширхэг	8.23
11	Автосамосвалын бэлэн байдал	%	82%

12	Автосамосвалын цаг ашиглалт	%	71%
13	Циклийн машины тоо (бүхэл)	ширхэг	9
14	Экс.н бэлэн байдал	%	83%
15	Экс.н цаг ашиглалт	%	77%
16	Автосамосвалын цагийн бүтээл	тн/ээлж	53.4

Хүснэгт 6.Шохойн чулуу тээвэрлэх хугацаа


САТ-374F, Хово-371		Замын төрөл	зай, м	Тээвэрлэх хурд		Туулах хугацаа		Нийт туулах хугацаа, мин
Уурхай Мөргөцөг	Бутлуурт			Ачаатай, км/цаг	Ачаагүй, км/цаг	Ачаатай, мин	Ачаагүй, мин	
R1-2	111	Налуу	200	20	25	0.60	0.48	1.08
		Дотор	968	25	30	2.32	1.94	4.26
		Гадна	10,300	30	35	20.60	17.66	38.26
		Үйлдвэр	1,900	20	25	5.70	4.56	10.26
		Нийт	13,368		26.25			53.86

Усны ашиглалт

Хөх цавын шохойн чулууны уурхайн нь нэг гүний худагтай ба тухайн худгийг улирлын чанартай ашигладаг. Усны зарцуулалт нь технологийн зам дагуу, шохойн бутлуур, карьерын талбайн тоосжилт дарах зорилгоор ашиглаж байна. Баталгаажсан тоолууртай ба хавар 4 сард Чандмань илт ХХК-иар тоолуур залгуулж намар 10 сард салгуулдаг. Тоолуурын заалтын дагуу усны төлбөрийг төлдөг. Тус уурхайн ажилчид нь цемент шохойн үйлдвэрийн бүсэд нэгдсэн байдлаар байрлан ажилладаг тул унд ахуй болон хаягдал ус нь үйлдвэрийн унд ахуй, хаягдал усны дүгнэлт, гэрээгээр зохицуулагддаг болно.

“ХӨХ ЦАВ” ШОХОЙН ЧУЛУУН УУРХАЙН УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
		I улирал			II улирал			III улирал			IV улирал			
Уурхайн ерөнхий мэдээлэл														
Шохойн чулуу олборлолт	тн/сар	132,308	119,591	20,315	135,813	140,779	137,312	141,982	141,738	137,149	121,984	95,688	130,936	1,455,594
Цемент үйлдвэрт олборлолт	тн/сар	113,713	103,067	1,721	117,909	122,185	119,407	123,388	123,143	119,245	103,390	77,783	112,341	1,237,292
Шохойн үйлдвэрт олборлолт	тн/сар	18,594	16,524	18,594	17,904	18,594	17,904	18,594	18,594	17,904	18,594	17,904	18,594	218,302
Цемент үйлдвэрт нийлүүлэлт	тн/сар	113,713	103,067	1,721	117,909	122,185	119,407	123,388	123,143	119,245	103,390	77,783	112,341	1,237,292
Шохойн үйлдвэрт нийлүүлэлт	тн/сар	5,913	5,341	6,242	-	3,561	6,994	7,227	7,227	6,803	6,899	-	6,570	62,776
Хөрс хуулалт	м3/сар	74,664	66,353	74,664	71,894	74,664	71,894	74,664	74,664	71,894	74,664	71,894	74,664	876,578
Уулын цул	м3/сар	123,667	110,646	82,188	122,195	126,805	122,750	127,250	127,160	122,690	119,844	107,334	123,159	1,415,687
Хөрс хуулалтын итгэлцүүр	м3/тн	0.6	0.6	3.7	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.6	0.8	0.6	0.60



УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн хүрээнд гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр буюу агаарын чанар, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, усан орчин, биологийн олон янз байдалд тодорхойлж, сөрөг нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Хөх цавын шохойн чулууны уурхайн ордоос шохойн чулуу олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2025 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг. Төсөл хэрэгжиж байгаа бүс нутагт “Хөх цавын шохойн чулуу уурхайгаас гадна Олон ихт баянт ХХК, Эко Хэлхээ ХХК-ны жонш баяжуулах үйлдвэр, нүүрс олборлож буй Чингэсийн хар алт, Штайнколе, Пауэрленд ХХК-ууд зэрэг аж ахуйн нэгжүүд төсөл хэрэгжүүлдэг учраас тухайн газрын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь хам шинж чанартай юм.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Дорноговь аймгийн Даланжаргалан суманд орших “Мак Цемент” ХХК-ийн хөх цавын шохойн чулууны уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-н сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-г баримталсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгахаар хуульчлагдсаныг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөний гол зорилтуудыг Хөх цавын шохойн чулууны уурхайн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний 9-р бүлэгт тусгагдсан БОМТөлөвлөгөөний дагуу хийж тайлант оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилт болон түүнийг тодорхойлж үнэлгээ өгсөн орон нутгийн холбогдох ажлын хэсгийн дүгнэлт, байгаль орчны төлөвлөгөөт аудитын зөвлөмж зэрэг баримт бичгүүд дээр үндэслэн тодорхойлов.

БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1 Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны тэнцлийг хадгалах зорилгоор орчны агаар дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино.

Хүснэгт 7. Агаарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн нөлөөллөөс агаарт тоосжилт үүсэх.	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгааг тогтмол хийх, бүртгэл хөтлөх	Уурхайн дотоод тээврийн зам талбай	тн	200,000.0	Тухай бүрт	200,000.0	Тухай бүрт	Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4585:2016 MNS4597:2014. Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS4585:2025. MNS 5885-2008
2		Тээврийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих	Тээврийн зам	км	ҮАЗ	Тухай бүрт	ҮАЗ	Тухай бүрт	
3		Тогтсон замын маршрутаар явж, зам талбайн тэмдэг тэмдэглэлээг нэмэгдүүлэх, засаж сайжруулах	Уурхайн дотоод тээврийн зам талбай	ш	200,000.0	5	200,000.0	Тухай бүрт	
4		Замын тоосжилтийг бууруулахад бороожуулагч систем турших	Уурхайн карьер, технологийн зам	-	1,000,000	Тухай бүрт	1,000,000	Жилдээ	
5	Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Дотоод тээврийн машинуудыг тодорхой дарааллаар цахилгаан тээврээр солих ажлыг эхлүүлэх	Уурхайн бүх хэсэгт	Машин ы тоо	ҮАЗ	ХОТ-н төлөвлө гөөнөөс хамаара х	ҮАЗ	Жилдээ	
		Нийт					3,400,000.0		

1.2 Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн ажилчдын унд ахуйн усны стандартыг хангах, уурхайн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 8. Усан орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

Дүрсэн 6: Ү сал орчны нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ									
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Усны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй газар доорх усны нөөц хомсдох	Ус ашиглах дүгнэлтийн дагуу гэрээ байгуулан ажиллах, гүний худгийн усыг ус ашиглах дүгнэлтэнд заасан хэмжээнд ашиглах	Зам усалгааны худаг	м³	ҮАЗ	1	ҮАЗ	Жилдээ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, холбогдох дүрэм журам, бусад стандартууд
2		Худгийн тоолуурын салгах, суурилуулах, бичилт хийх, үйл явцад хяналт тавьж ажиллах, сар бүрийн тоолуурын заалтыг сумын БО-ны мэргэжилтэнгээр баталгаажуулах, төлбөр төлөх	Зам усалгааны худаг	-	450,000.0	2	900,000.0	Жилдээ	
3		Дэлхийн усны өдөрлөгөөр уурхайн хүрээнд усны хэрэглээг бууруулах, хэмнэлттэй ашиглах талаар уурхайн нийт ажилчдад сургалт зохион байгуулах, орон нутгийн ЕБС-тэй хамтарч өдөрлөг зохион байгуулах	Зам усалгааны худаг	-	ҮАЗ	Тухай бүр	ҮАЗ	3 сар	
	Нийт						900,000.0		

1.3 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хөрсний элэгдэл эвдрэл, бохирдлыг багасгах байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, уурхайгаас хуулсан шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүйгээр хадгалах, арчлах.

Хүснэгт 9. Хөрсөнд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрсний элэгдэл үүсэх	Уурхайн үйл ажиллагааны явцад шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах, түүнд тогтмол хяналт тавьж ажиллах	Уурхайн ахилтын талбай	га	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрд	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрт	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартын Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хууль, холбогдох дүрэм журам, стандарт
2	Хөрсний бохирдол үүсэх	Техникийн тосолгоо, угаалга зэрэг засвар үйлчилгээг зориулалтын талбайд хийх	Үйлдвэрийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрд	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрд	
3	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх	Уурхайн гадаад, дотоод замын хөрс эвдэрч суларсан тохиолдолд хусаж засварлах	Уурхайн хэмжээнд	км	200,000.0	Тухай бүрд	200,000.0	Тухай бүрд	
4		Уулын ажлын төлөвлөгөөний дагуу газар хөндөх үед зөвшөөрөл, бүртгэл мэдээллийг хөтлөх, хяналт тавин ажиллах	Уурхайн хэмжээнд	га	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрд	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	
5	Хүнд машин механизм, машин техникээс ШТМ асгарч, улмаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, сургалт орох, асгаралтын иж бүрдлийг засвар үйлчилгээний талбайд байршуулах	Үйлдвэрийн бүс	ш	1,000,000	ҮА	1,000,000	Жилдээ	MNS5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Нийт						1,200,000.0		

1.4 Ургамлан бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Зорилго: Уурхайн орчны ургамал, амьтны аймгийг тогтмол бүртгэж, хамгаалах, уурхайн үйл ажиллагаанаас ургамал, амьтанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 10. Амьтан, ургамалд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагаагаар талбай эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг устгах	Хөндөгдөж буй талбайн ургамлын зүйлийн бүртгэл хөтлөх	Төслийн талбайн хэмжээнд	м2	Үйл ажиллагааны зардал	Тухай бүр	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	MNS5917:2008. Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5918:2023. Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага
2	Уурхай орчмын бэлчээрийн талбайн мониторинг хийх	Ургамлын мониторинг хийх		м2	250,000.0	2	500,000	6,9 сар	
3	Төслийн технологийн зам дагуу олон салаа зам гаргахгүй байх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх		км	Үйл ажиллагааны зардал	Тухай бүр	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	
4	Уурхайн үйл ажиллагаанаас хамаарч биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих, Дотоод болон гадаад тээврийн зам нь зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, хуваагдал үүсгэх	Зэрлэг амьтны тархац, шувуудын тархац, махчин шувуудын үүрний байршлыг тогтоох, хийх, мониторингийн ажлыг гүйцэтгэх	Технологийн зам дагуу	га	Үйл ажиллагааны зардал	2	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	Амьтны тухай хууль
5		Уурхайн ажилчдад ан амьтны талаарх мэдээллийг нийт ажилтанд мэдээлж, сургалт орох, уурхайн бүсэд зэрлэг амьтан нэвтэрсэн тохиолдолд БОТХХ-г мэдэгдэх	Технологийн зам дагуу	га	Үйл ажиллагааны зардал	2	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	
	Нийт						500,000.0		

1.5 Ногоон байгууламжийн төлөвлөгөө

Газрын тухай хуулийн 56.6-р зүйл, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйлд заасны дагуу газар эзэмшигч нь эзэмшлийн талбайн 10 хувиас багагүй талбайд ногоон байгууламж байгуулахаар заасан байдаг. Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж байгаа билээ. Төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн онцлогт тохирсон мод бутыг тарьж байна.

Хөх цавын шохойн чулууны уурхайн 2026 оны БОМТ-ний хүрээнд 500 ш модыг үйлдвэрийн бүсэд нэгдсэн усалгааны системд түшиглэж тарихаар төлөвлөсөн. БОННУ-нд жил бүр 1,2 сая төгрөг зарцуулахаар урьдчилан байдлаар тусгасан бөгөөд үүнийг “МАК Цемент” ХХК-ийн 2026 оны үйл ажиллагааны зардалаас нэгдсэн байдлаар модны суулгац болон тээвэрлэлт, ажиллах хүчний зардалыг жил бүр тооцож гарган ажилладаг. Тиймээс БОМТ-ний зардалд тусгаагүй болно.

БҮЛЭГ 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн ажлыг ил уурхайн эвдрэлд өртсөн 14.1 га талбайн хүрээнд тооцох шаардлагатай боловч орд нь хэвгий уналтай, 10 жилийн хугацаанд 1255-1205 м-ийн түвшин хүртэл 50 м-ийн гүнд олборлолт явагдах тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх хугацаа болоогүй юм. Нөхөн сэргээлт хийгдэхгүй.

БҮЛЭГ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг холбогдох хууль дүрэм журмын дагуу боловсруулахаар төлөвлөсөн ба мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн БОННУ-нд дурьдсан дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дагуу 2026 онд уурхайн дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг боловсруулан хийхээр төлөвлөж байна.

Хөх цавын шохойн чулууны уурхай нь 2026 оны дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутгийн санал болон БОННУ-нд тусгагдсан саналыг харилцан тусгаж үзэж дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах Амьдрах орчныг сайжруулах	Орон нутгийн санал авах	Орон нутгийн саналын дагуу	1	33,650,000.0	33,650,000.0	1	Байгаль орчинд нөлөөлөх

								байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт					33,650,000.0		

БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөх цавын шохойн чулууны уурхай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах ба 2026 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА

ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай компани нь 2013 онд палеонтологийн хайгуул, судалгааны ажил хийгдсэн бөгөөд энэ хайгуул малталт, судалгааны ажлаар 1ш 240х160 см харьцаатай чулуун байгууламж олдож байсан. Уурхайн үйл ажиллагааны явцад санамсаргүйгээр археологи ба палеонтологийн олдворууд олдож болзошгүй тул үйл ажиллагааны явцад санамсаргүй олдворууд олдсон тохиолдолд Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын дагуу дагаж мөрдөн ажиллана.

Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэнгээр Хөх цавын шохойн чулууны уурхайн тэсрэх материалын агуулахын 1 га, хөрсний овоолгын 27.3 га, хотхоны 1 га, 10.5 километр үргэлжлэх сайжруулсан шороон замын трасс, 9.8 км үргэлжлэх цахилгаан дамжуулах шугамын дагуух талбайнуудад археологи болон угсаатны зүйн авран хамгаалах, хайгуул судалгааг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 12. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологи палеонтологийн дурсгалт эд өлгийн зүйл	Олдвор илэрвэл мэдэгдэх	Уурхайн ажилчид	1	50,000.0	50,000.0	Илэрсэн тохиолдолд	МАК ХХК санамсаргүй олдворын үед ажиллах журам
		Нийт				50,000.0		

БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“МАК Цемент” ХХК нь 2025 онд ISO 45001:2018 ХАБЭА олон улсын стандартыг нэвтрүүлээд байна. Уурхайн ажиллагсадын эрүүл мэнд, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд оршино.

Хүснэгт 13. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайд ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан, давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Нийт ажилтан	Тухай бүр	ҮАЗ	ҮАЗ	Жилдээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль ISO45001 ийн хүрээнд стандарт хэрэгжилтийг хангах
2		Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, байгаль орчны хяналт мониторинг хийх	Уурхайн хэмжээнд	Тухай бүр	100,000.0	100,000.0	Жилдээ	
3	Гал түймэр	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламж	1	100,000.0	100,000.0	Жилдээ	
4		Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдүүлж ажиллах	ХЭМАБХ-тэй хамтарч хийх	1	ҮАЗ	ҮАЗ	Жилдээ	Галын аюулгүй байдлын тухай хууль MNS4244:1994 . Хөдөлмөр хамгааллын систем Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS0639:2016 . Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томьёо ба тодорхойлолт
5		Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсад мэргэжлийн байгууллагын тусламжтай сургалт зохион байгуулах	ХЭМАБХ-тэй хамтарч хийх	1	ҮАЗ	ҮАЗ	Жилдээ	
	Нийт					200,000.0		

БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөөлийг хурдан хугацаанд арилгахад оршино.

Компаний хэмжээнд мөрдөгдөж байгаа “Үйлдвэр, уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г дагаж мөрдөх ба Уурхайн хог хаягдал ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмын дагуу ажиллана.

Машин техникүүдийн үйлчилгээг үйлдвэрийн засвар үйлчилгээний төвд хийдэг. Засвар үйлчилгээнээс гарах хаягдал ШТМ-ыг аюултай хог хаягдал хадгалах талбайд зориулалтын саванд цуглуулдаг ба Цемент шохойн үйлдвэр нь нэгдсэн журмаар хаягдал ШТМ-ыг дахин ашиглах эрх бүхий “ОБ-Ойл ХХК, Монопит ойл ХХК болон Саус ресурс ХХК”-тай гэрээний дагуу нийлүүлнэ.

Уурхайн хог хаягдал: Ахуйн хэрэглээний хог хаягдлыг Даланжаргалан сумтай хог хаягдлын гэрээ байгуулж зөвшөөрөлтэй хогийн цэгт зайлуулна. Мөн шил, лааз, хуванцар сав зэрэг дахивар хог хаягдлыг тусад нь цуглуулан хадгалж “Төвшин мөнх төв НҮТББ”-д нийлүүлнэ.

Хог хаягдлаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөв.

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжийг бүрдүүлэн ажиллах, бүртгэл хөтлөх, хяналт тавих	Уурхайн хэмжээнд	тн	100,000.0	Тухай бүрд	100,000.0	Жилдээ	Хог хаягдлын тухай болон бусад хууль, холбогдох дүрэм журам, стандарт
2		Энгийн болон аюултай хог хаягдал, түүний ангилан ялгалтын тухай мэдээллээр хангах	Уурхайн хэмжээнд	Нийт ажилтан	Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	
3		Дахивар хог хаягдлыг ангилан ялгаж холбогдох аж ахуй нэгжид нийлүүлэх	Уурхайн хэмжээнд	тн	100,000.0	1	100,000.0	Жилдээ	
4		Уурхай орчмын хог хаягдлын цэвэрлэгээг хуваарийн дагуу хийх	Уурхайн хэмжээнд	га	100,000.0	Тухай бүрд	100,000.0	Жилдээ	
5	Аюултай	Аюултай хог хаягдалыг үйлдвэрийн нэгдсэн засвар үйлчилгээ талбайд хадгална. Гэрээт компанид нийлүүлэх	Уурхайн хэмжээнд	тн	100,000.0	-	100,000.0	Жилдээ	
Нийт							400,000.0		

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Зардал (1 жил),₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1		2	3	4	5	7
Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр						
1	Дуу чимээ	- Ил уурхай - Зам дагуу 2	3	-	200,000	MNS 4585:2025.
2	Агаарын чанар Орчны тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀ TSP, CO, NO ₂ , SO ₂)	- Уурхайн зам 1 - Ил уурхай 1 - Зогсоол 1	3	7 хоногт 1 удаа	100,000	MNS 4585:2025 MNS ISO 4227-2002
3	Ургамлан нөмрөг Ургамлын зүйлийн бүрдэл Ургамлан нөмрөгийн бүрхэц	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд	3	Жилд 1 удаа	100,000	Батлагдсан арга зүйн дагуу
4	Амьтдын аймаг Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг Амьтдын тоо толгой	Төслийн талбай болон түүний ойролцоох уст цэг, мод бутлаг ургамал бүхий талбайд	3	Жилд 1 удаа	ҮАЗ	
Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр						
1	Агаарын чанар Орчны тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀ TSP, CO, NO ₂ , SO ₂)	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	3	Жилд 1 удаа	1 дээж 100,000*3 Жилд 600,000	MNS4585:2025. MNS ISO4227-2002
2	Хөрсний хими болон физик Хүнд металл	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	3	Жилд 1удаа	1 дээж 35,000*3 Жилд 105,000	MNS 2305:1994 MNS 5850:2019
3	Усан орчин Ерөнхий хими, физикийн шинжилгээ Хүнд металлын шинжилгээ	Хөх цавын худаг	1	Жилд 1 удаа	1 дээж 30,000*1 Жилд 30,000	MNS 0900:2018 MNS6148:2010 MNS ISO5667-11:2000.
Хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөр						

1	Нөлөөллийн бүсийн малчдын худгийн усны хэмжилт хамтран хийх	Үйл ажиллагааны зардалд тусгах
Нийт		1,135,000 төгрөг

БҮЛЭГ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаа явуулах хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, сурталчилгаа, мөрдөгдөх журам, төлөвлөгөөг цаг алдалгүй хийх тухайн ажлыг зөв зүйтэй зохион байгуулахад оршино.

Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026				
			Сар	Сар	сар		
1	Байгаль орчны сургалтад нийт ажилтнуудыг хамруулах, оролцоог нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах	65,000.0	5		9	БОТХХ, ХАБЭА	-
2	Уурхайн газрын гэрээг хийж, төлбөр төлөх	Газрын гэрээгээр	Улирал тутам			УХХ	-
3	Уурхайн ус ашиглах дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авах, гэрээ байгуулах, төлбөр төлөх	Гэрээгээр	1-р улирал			Байгаль орчин тогтвортой хөгжлийн мэргэжилтэн	-
4	Уурхайн хог хаягдлын гэрээг байгуулж, төлбөр төлөх	Хог хаягдлын гэрээгээр	1	5	10		-
5	Нөлөөллийн бүсийн малчдад өвс тараах	2,000,000.00	-	-	1	Уурхайн удирдлага, Байгаль орчин тогтвортой хөгжлийн мэргэжилтэн	-
6	Эрүүл мэндийн үзлэгт нөлөөллийн бүсийн малчдыг хамруулах	Үйл ажиллагааны зардал	-	2-3	10	Уурхайн удирдлага, Байгаль орчин тогтвортой хөгжлийн мэргэжилтэн	-
	Нийт	2,065,000.0					

БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орон нутгийн иргэд болон төрийн байгууллагыг үнэн зөв бодит мэдээллээр хангахад оршино.

Хүснэгт 17. Олон нийтэд тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, сая төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Дорноговь аймгийн Даланжаргалан сумын багийн иргэд нийтийн хуралд	БОМТ-ний хүрээнд гүйцэтгэсэн ажлын хураангуй	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн хураангуй танилцуулга	Тухайн жилд	Үйл ажиллагааны зардалд тусгав.	Байгаль орчны хэлтэс	Бичигт 3-р баг
2	Дорноговь аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн гүйцэтгэсэн тайлан. Ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажуулна	11 дүгээр сарын 01-ээс өмнө			Дорноговь аймаг
3	Байгаль Орчин, Уур Амьсгал Өөрчлөлтийн яам			12-р сарын 30-аас өмнө			Улаанбаатар хот
4	Нийт зардал: Үйл ажиллагааны зардлаас						

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО

2026 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ 42,300,000.00 төгрөгийг урьдчилсан байдлаар зарцуулахаар байна.

Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний урьдчилсан зардал

Дд	Хийгдэх ажлууд	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,800,000.0
2	Нөхөн сэргээлтийн ажил	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	33,650,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговрын зардал	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах зардал	50,000.0
6	Осол эрдэслийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	200,000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	400,000.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2,065,000.0
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэхэд гарах зардал	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,135,000.0
Нийт		42,300,000.00